

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: javkhlan@khurdan.gov.mn цахим шуудан
- Холбоо барих утас: 260304, 88102031

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Газрын дарга	1	Төрийн захиргааны удирдах	Эрхэлсэн түшмэл ТЗ-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Zahirgaa-udirdlagiin-gazriin-dargiin-ATT-1.pdf	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
2	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Чанар хяналтын газар	Газрын дарга	1	Төрийн захиргааны удирдах	Эрхэлсэн түшмэл ТЗ-3	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Chanar-hyanaltiin-gazriin-dargiin-ATT_1.pdf	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх;	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх;
3	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-6	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Togtool-shidweriin-hergejilt-tailan-tuluvluguu-hariutssan-mergejiltnei-ATT.pdf	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;

4	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Хуулийн ахлах мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-6	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Huuliin-ahlah-mergejiltanii-ATT.pdf	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;
5	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Хүний нөөцийн мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Hunii-nuutsiin-mergejiltanii-ATT.pdf	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;
6	Төрийн цахим, үйлчилгээний зохицуулалтын газар	Захиргаа удирдлагын газар	Хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	https://mddc.gov.mn/wp-content/uploads/2023/04/Hyanalt-shinijilgee-unelgee-hariutssan-mergejiltanii-ATT.pdf	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно;